

**ЭМНЕСТИ ИНТЕРНЭШЛЭЭС ОЛОН НИЙТЭД ХАНДАЖ ГАРГАСАН МЭДЭГДЭЛ**

2020 оны 3 сарын 20-ны өдөр

Индексийн дугаар POL 30/1967/2020

УЛС ОРНУУДЫН КОВИД-19 ВИРУСИЙН ХАЛДВАРЫН ЭСРЭГ АВЧ БУЙ АРГА ХЭМЖЭЭ БОЛОН ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА: ЭХНИЙ АЖИГЛАЛТ

АГУУЛГА

Өмнөтгөл

Ард иргэдийг Ковид-19 вирусийн халдварт өртөхөөс урьдчилан сэргийлэх нь

- Хорио цээрийн дэглэм
- Аяллын хориг ба хязгаарлалт
- Мэдээллийн хүртээмж, ил тод байдал ба цензур
- Урьдчилан сэргийлэх арга хэмжээ, бүтээгдэхүүн, үйлчилгээ
- Онцгой байдлын үе

Халдвар авсан хүмүүст үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмж

- Тусламж үйлчилгээний хүртээмж ба үнийн боломжит байдал
- Халдварын өндөр эрсдэлтэй бүлгийнхэнд тусах ноцтой, тэгш бус нөлөөлөл
- Нийгмийн аюулгүй байдал ба ажилчдын эрх
- Гутаан доромжлох ба ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх нь
- Эрүүл мэндийн ажилтнуудыг хамгаалах нь

Олон улсын хамтын ажиллагаа ба тусламж

Урт хугацаанд эргэн сэргээх үйл явц, биелэлтийг эргэн хянах нь

Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, халдварт өртөх өндөр эрсдэлтэй хүмүүст дэмжлэг үзүүлэхийн тулд Ковид-19 халдварт өртсөн улс орон бүрийн Засгийн газар, бусад оролцогч уг халдварын эсрэг авч буй бүхий л арга хэмжээндээ хүний эрхийн олон улсын хэм хэмжээг баримтлах ёстой. Энэхүү баримт бичигт (1) цар тахлын үед, тухайлбал, Ковид-19 халдварын үед улс орнуудын бүх шатанд авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд тулгамдаж буй хүний эрхийн асуудал, сорилтууд, мөн (2) хүний эрхийн талаар авч хэрэгжүүлэх засгийн газруудын үүрэг, авч хэрэгжүүлэх аливаа арга хэмжээндээ баримтлах хүний эрхийн гол хууль, хэм хэмжээ, зарчмуудыг хураангуйлан авч үзэв. Энд нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хорио цээрийн дэглэм, аяллын хориг зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ засгийн газруудын анхаарвал зохих хүний эрхийн асуудлыг авч хэлэлцсэн. Тухайлан урьдчилан сэргийлэх тусламж үйлчилгээ, бараа бүтээгдэхүүний хүрэлцээ, хүртээмж болоод үнийн боломжит байдал, нийгмийн аюулгүй байдал ба эмнэлгийн ажилтнуудын эрхийг хангах, гутаан доромжлох, ялгаварлах явдлаас сэргийлэх, эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг хамгаалах зэрэг төрийн хэрэгжүүлэх үүргүүдийн талаар хөндсөн болно. Мөн олон улсын хамтын ажиллагаа болоод, тусламжийг зохицуулах, урт хугацаанд эргэн сэргээх үйл явц, биелэлтийг эргэн шалгах төрийн үүргийг авч үзсэн болно.



ӨМНӨТГӨЛ

Энэ баримт бичгийг гаргаж байх үед дэлхийн бүх тивийн 100 гаруй улсад Ковид-19 вирусийн халдварын 113,702 батлагдсан тохиолдол бүртгэгдэж, 4000 гаруй хүн амь насаа алдаад байна.¹ ДЭМБ уг өвчнийг *цар тахал* хэмээн тодорхойллоо.² Уг цар тахалын эсрэг арга хэмжээ авахаар хичээж буй улс орнууд, тэдний хүчин чармайлтыг дэмжиж буй засгийн газар хоорондын, төрийн бус оролцогчид, мөн өвчлөл гарсан улс орнуудын иргэд, Ковид-19 вирусийн халдварын эрсдэлтэй нүүр тулж буй эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын хувьд ихээхэн хүнд цаг үе тулгараад байна.

Нийгмийн эрүүл мэнд, эрсдэлт нөхцөлд байгаа хүмүүс, бүлгийнхнийг хамгаалахын тулд халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлаа хангах, халдварыг тогтоон барих, эмчлэх зэрэг бүхий л хүчин чармайлтын төвд хүний эрхийн асуудлыг тавих ёстой. Гэтэл, халдвар авсан, халдварын эрсдэлтэй хүмүүс, эсвэл олон нийтэд учирч болзошгүй үр дагавруудыг бүрэн авч үзэхгүйгээр Ковид-19 вирусийн халдварыг тогтоон барих олон арга хэмжээг санал болгож, хэрэгжүүлсэн бололтой. Засгийн газруудын үүрэг бол хүний эрхийн харилцан хамааралтай, салшгүй байх зарчмын дагуу иргэний, соёлын, эдийн засгийн, улс төрийн болон нийгмийн эрхүүдийг хангах явдал юм. Хүний эрхийг хямралт байдлын ямар ч үе шатанд бүрэн дүүрэн хангах ёстой бөгөөд нийгмийн эрүүл мэндэд учирсан хохирлыг багасгасан тохиолдолд л хэрэгжүүлж болох тансаглал гэж үзэж болохгүй. Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлаас шалтгаалан оршин байгаа газраа орхин нүүх болсон хүмүүс ч мөн адил хүний эрхийн хууль тогтоомжийн дагуу бүрэн дүүрэн, үр нөлөөтэй хамгаалагдах эрхтэй. Ялангуяа халдвар авсан, эрсдэлт бүлгийн хүмүүс ч мөн бусдын адил эрх эдлэх учиртай.

Өндөр настан, архаг өвчтэй хүмүүс (амьсгалын замын, зүрх судасны, сэтгэл зүйн, хавдар зэрэг өвчнөөр оношлогдсон, эмчийн хяналтад эмчилгээ хийгдэж байсан зэрэг) Ковид-19 вирусийн халдвар авсан тохиолдолд хүндээр өвчлөх, амь насаа алдах өндөр эрсдэлтэй байна. Мөн ядуус, усны хомсдолтой, зохих ариун цэврийн байгууламжгүй хүмүүс вирусаас өөрсдийгөө зохих түвшинд хамгаалахад нь нэмэлт саад бэрхшээл тулгарч байгаа нь дамжиггүй. Засгийн газрууд Ковид-19 вирусийн эсрэг авах арга хэмжээгээ төлөвлөхдөө энэхүү халдварын тодорхой бүлэг хүмүүст тусах нөлөөллийг сайтар бодолцож, тэдний хэрэгцээ шаардлага, амьдралын туршлагыг төлөвлөгөө, стратегидаа тооцож үзвэл зохино.

Эрүүл мэндтэй холбоотой эрх нь олон улсын хүний эрхийн хэд хэдэн гэрээнд тусгагдсан байдаг ба дэлхийн ихэнх улс орнууд иргэдийнхээ эрүүл мэндийн асуудалд хүндэтгэлтэй хандах, хамгаалах, хэрэгжүүлэх үүрэг бүхий дор хаяж нэг гэрээг соёрхон баталсан байдаг. Эдгээрээс хамгийн чухал нь, ЭЗНСЭОУП-ын 12-р зүйлд заасан “хүн бүрийн бие бялдрын болон сэтгэцийн эрүүл мэнд дээд түвшинд хүрсэн байх эрхийг” хангах, мөн “халдварт өвчин, тухайн орон нутгийн өвчин, мэргэжлийн болон бусад өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, хяналтандаа байлгахад” шаардлагатай арга хэмжээ авахыг баталгаажуулсан байх явдал юм. ЭЗНСЭОУП-ын хэрэгжилтийг хянах үүрэг бүхий НҮБ-ын Эдийн Засаг, Нийгэм, Соёлын Эрхийн Хороо (ЭЗНСЭХ)-ноос уг эрхтэй холбоотой засгийн газруудын үүргүүдийг тайлбарласан, тухайлбал Ерөнхий санал зөвлөмж №14.3 дахь хэсэг³ нарийвчилсан байдаг. Хорооны зөвлөснөөр, “халдварт өвчин, тухайн орон нутгийн өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, хянах арга хэмжээ” нь “нэн тэргүүнд хэрэгжүүлэх үүрэг хариуцлага” бөгөөд эрүүл мэндээ хамгаалуулах (“шаардлагатай, наад захын түвшинд”) эрхийг хангах хамгийн гол үүрэг болно. Аль ч улс орон, ямар ч нөхцөлд эдгээр “хөндөж үл болох” үндсэн эрхийг хангаагүй явдлаа зөвтгөх ёсгүй гэж Хороо мэдэгдсэн байдаг.⁴

¹ 2020 оны 3 сарын 10-ны байдлаар, жишээ болгож KFF, Global Health Policy Tracker, www.kff.org/global-health-policy/fact-sheet/coronavirus-tracker/-г үз, ДЭМБ, Коронавирусийн өвчлөл (COVID-2019) Нөхцөл байдлын тайланг үз, www.who.int/emergencies/diseases/novel-coronavirus-2019/situation-reports

² ДЭМБ, *ДЭМБ Ковид-19-ийг цар тахал хэмээн зарлалаа*. 2020 оны 3 сарын 11. www.who.int/emergencies/diseases/novel-coronavirus-2019/events-as-theyhappen

³ Эдийн засаг, Нийгэм, Соёлын Эрхийн Хорооны 14-р санал зөвлөмж, Эрүүл мэндийн боломжит дээд стандартыг хүртэх эрх, ЭЗНСЭОУП-ын 12-р зүйл, НҮБ-ын бичиг баримт. E/C.12/2000/4 (2000) (Үүнээс хойш: ЭЗНСЭХ Ерөнхий санал зөвлөмж 14 гэх).

⁴ ЭЗНСЭХ Ерөнхий санал зөвлөмж №14, 43, 44, 47-р догол мөр. 47-р догол мөрд “үндсэн үүрэг”, 43-р догол мөрөнд “хөндөж үл болох үндсэн эрхүүд”-ийг тайлбарласан. 43, 44-р догол мөрөнд улс орнуудын хэрэгжүүлбэл зохих “нэн тэргүүний үүргийн” жагсаалт байх ба адил тэгш хэрэгжүүлэх ёстойг заасан байдаг.

ИРГЭДИЙГ КОВИД-19 ВИРУСИЙН ХАЛДВАРТ ӨРТӨХӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

ХОРИО ЦЭЭРИЙН ДЭГЛЭМ

Халдварт өвчний тархалтыг хяналтандаа оруулах зорилгоор түгээмэл хэрэглэдэг хорио цээрийн дэглэм (халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн эсвэл илэрч болзошгүй хүмүүсийг тусгаарлах)-ийг Ковид-19 вирусийн эсрэг улс орнуудын авч хэрэгжүүлж байна. Одоогийн байдлаар хорио цээрийн дэглэмийг янз бүрийн хэмжээгээр тогтоож байна. Зарим газар бүхэл бүтэн хот, бүс нутгийн хэмжээнд тогтоож байгааг холбогдох мэдээллээс харж болно.⁵ Хорио цээрийн дэглэм нь хувь хүний чөлөөтэй зорчих эрхийг хөндөхөөс гадна хүмүүс дэглэмийг хэрхэн хэрэгжүүлж, эрх чөлөөг нь хэр хэмжээнд хязгаарлаж байгаагаас хамаардаг. Хорио цээрийн дэглэмд байгаагийн улмаас эрхээ эдлэхэд нь саад бэрхшээл учирч буй жишээнээс дурдвал, ажилдаа явж чадахгүйгээс ажлын байр, цалин хөлсөнд нь сөргөөр нөлөөлөх, хоол хүнс, эрүүл ахуйн хангамж, эрүүл мэндийн үйлчилгээ үндсэн, наад захын хэрэгцээгээ хангаж чадахгүй байгаа гэсэн мэдээлэл байна.⁶ Ядуу хүмүүс хоол хүнс болон хэрэгцээт бусад зүйл, эрүүл мэндийн үйлчилгээ авах хангалттай нөөцгүй байдгаас хорио цээрийн дэглэм тэдэнд тэгш бус байдлаар тусч, хүний эрхийн зөрчил үүсгэж болзошгүй. Тэд цалингүй чөлөөний хугацааг давах хангалттай нөөцгүй байж болно. Хүний эрхийн олон улсын эрх зүйн дагуу цөөн тооны нөхцөл байдалд л хорио цээрийн дэглэмийг зөвшөөрдөг.

НҮБ-ын ИУТЭОУП-д зааснаар, хэрвээ хууль, тогтоомжид тусгагдсан бол, олон нийтийн эрүүл мэнд зэрэг тодорхой хууль ёсны зорилгыг хамгаалахын тулд "Пактаар хүлээн зөвшөөрсөн бусад эрхтэй нийцэж байгаа" нөхцөлд чөлөөтэй зорчих эрхийг хязгаарлаж болно.⁷ ИУТЭОУП-ын заалтаас ухрах болон хязгаарлалт тогтоох талаарх Сиракусын Зарчим (Сиракусын Зарчим) болон шинжээчийн Пактын талаарх тайлбарын дагуу хэзээ, хэрхэн хүний эрхийг хязгаарлах талаар дараах зөвлөмжийг өгсөн байдаг.⁸ Үүнд, (i) Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг хязгаарлахдаа ямар нэг байдлаар ялгаварлахгүй байх, (ii) аливаа хязгаарлалт нь нийгмийн, олон нийтийн тулгамдсан хэрэгцээний хариу арга хэмжээ болж, хууль ёсны зорилгоо биелүүлэх ба энэхүү зорилготойгоо эн тэнцүү байх,⁹ (iii) улс орнууд хязгаарлалт хийж буй зорилгодоо хүрэхэд шаардлагатайгаас илүүгээр хязгаарлах арга хэрэгсэл ашиглах ёсгүй, (iv) Пактын дагуу баталгаажсан эрхийг хязгаарласан шалтгаанаа тухай улс өөрөө тайлбарлана,¹⁰ (v) тухайн хязгаарлалтыг зүй бусаар ашиглахын эсрэг арга хэмжээ авах, мөн тулгарч болзошгүй бэрхшээлийг харгалзаж үзсэн байна. Олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс хүний эрхийг хязгаарлах тохиолдолд "авах арга

⁵ Бизнес инсайдер, Хятадын Ухань хотод урьд өмнө тохиолдож байгаагүй хөл хорионд 11 сая хүн 3 долоо хоног болж байна. Хот эзэнгүй юм шиг болжээ. 2020 оны 2 сарын 15. www.businessinsider.com/wuhan-coronavirus-what-life-like-inside-quarantined-city-china-2020-2?r=US&IR=T; БиБиСигийн мэдээ: Италийн улаан бүсэд хорио цээрийн дэглэм тогтоолоо, www.bbc.co.uk/news/world-europe-51651099; Аль Жазира: Японы засгийн газар хөлөг онгоцон дээрх хөл хориг зохицуулж чадахгүй байна, www.aljazeera.com/news/2020/02/coronavirus-japan-govt-defends-handling-ship-quarantine-20022011441912.html

⁶ Си Эн Эн, Ухань дахь халдвар аваагүй иргэдийг корона вирусийн олныг хамарсан хөл хорионд оруулсан нь халдвар авах эрсдэлтэй байна гэж мэдээлжээ, 2020 оны 2 сарын 24, edition.cnn.com/2020/02/22/asia/china-coronavirus-roundup-intl-hnk/index.html

⁷ ИУТЭОУП, 12.3 дахь хэсэг

⁸ ИУТЭОУП-ын заалтаас ухарах болон хязгаарлалт тогтоо талаарх, ухрах асуудлаарх Сиракусын Зарчим (Сиракусын Зарчим), НҮБ-ын баримт бичиг, E/CN.4/1984/4 (1984) (цаашид Сиракусын Зарчим гэх). ИУТЭОУП-ын талаарх Ерөнхий санал зөвлөмжүүдийн дагуу хүний эрхийг хязгаарлах үндэслэлийн тухай зөвлөмжийг Хүний Эрхийн Хорооноос гаргасан ба, үүнд аливаа хязгаарлалтыг тайлбарлах, тухайн арга хэмжээг хуульд тусгасан эсэх, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлага, тулгамдсан асуудалтай тэнцэхүйц байх, мөн дахин хянаж үзэх талаар улс орнуудын хүлээсэн үүрэг хариуцлагыг онцолсон байна. Жишээ нь, Пактын 9-р зүйлд заасан хүний эрх чөлөө, аюулгүй байдалтай холбоотойгоор эмнэлэгт албадан хэвтүүлэх тохиолдолд "ямар ч нөхцөлд шаардлагатайгаас илүү хугацаагаар саатуулах ёсгүй ба саатуулах хугацаа хязгаартай байна, ямар ч тохиолдолд 9-р зүйлд заасан эрхийг хүндэтгэж, баталгаатай эдлүүлэх" үүргийг улс орнууд биелүүлэх ёстойг Хүний эрхийн Хороо онцолж байна. Саатуулагдсан шалтгааныг саатуулагдсан иргэнд мэдэгдэх ёстой ба тухайн иргэнийг тусгайлан хууль зүйн зөвлөгөө, хууль зүйн туслалцаа авах боломжоор хангах ёстой. Хүний эрхийн хороо, Ерөнхий санал зөвлөмж №35, 9-р зүйл, (Хүний эрх чөлөө, аюулгүй байдал) 2014, НҮБ-ын баримт бичиг. ССРР/С/ГС/35 (2014), para. 15. Пактын 19-р зүйлд заасан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй холбоотойгоор, олон нийтийн эрүүл мэндийн талаар хэрэгжүүлж буй хязгаарлалт нь зайлшгүй, тулгамдсан асуудалтай тэнцэхүйц байх, мөн "хэтрэхгүй байх" ёстойг Хүний эрхийн хороо онцолж байна. Хүний эрхийн хороо, Ерөнхий санал зөвлөмж №34, 19-р зүйл: Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө (2011), НҮБ-ын баримт бичиг. ССРР/С/ГС/34, para. 34. Олон нийтийн эрүүл мэндийн төлөө хэрэгжүүлж буй зорчих хөдөлгөөний аливаа хязгаарлалт нь "хууль тогтоомжид тусгагдсан, ардчилсан нийгмийн зорилтуудыг хамгаалахад шаардлагатай, Пактаар хамгаалагдсан бусад эрхтэй нийцсэн байх", "ялгаварлахгүй байх, тулгамдсан асуудалтай тэнцэхүйц, мөн хүрээ хязгаар нь тодорхой байх" ёстой. ИУТЭОУП Ерөнхий санал зөвлөмж №27: 12-р зүйл (Чөлөөтэй зорчих эрх) (1999), НҮБ-ын баримт бичиг, ССРР/С/21/Rev.1/Add.9, paras 11-18.

⁹ ЭЗНСЭОУП-ын Ерөнхий санал зөвлөмж №14, 29-р догол мөр, аливаа хязгаарлалт нь "тухайн тулгамдсан асуудалтай тэнцэхүйц...", "... тодорхой хугацаатай, мөн эргэн хянах үзэх шаардлагатай" байна.

¹⁰ Сиракусын зарчим, 8-12-р заалт, "Оролцогч улсууд онцгой байдлын үед хэрэглэх хүний эрхийн стандартыг олон улсын эрх зүйн хүрээнд боловсруулах талаар анхаарч үзэх ёстой" гэж Сиракусын зарчимд тусгагдсаныг Хүний эрхийн хороо цохон тэмдэглэв. ЭЗНСЭОУП, Ерөнхий санал зөвлөмж №29, Онц байдлын үе. (4-р зүйл), НҮБ-ын баримт бичиг. ССРР/С/21/Rev.1/Add.11 (2001), para. 10.

хэмжээ нь зөвхөн өвчнөөс урьдчилан сэргийлэх, эсвэл өвчтэй, гэмтэж бэртсэн хүмүүст тусламж үзүүлэхэд чиглэгдэх ёстой” гэдгийг Сиракусын зарчим дахин давтан сануулж байна.¹¹

ЭЗНСХ-ны 14-р санал зөвлөмжид энэ талаар цаашид зөвлөхдөө, олон нийтийн эрүүл мэндийн төлөөх аливаа хязгаарлалт нь “олон улсын хүний эрхийн хэм хэмжээ болон хуульд нийцсэн, Пактаар хамгаалагдсан эрхийн мөн чанар болон хууль ёсны зорилго, ардчилсан нийгмийн сайн сайхныг хангах зайлшгүй шаардлагатай нийцсэн байх ёстой” гэжээ.¹² Эдгээр хязгаарлалт нь тодорхой хугацаатай, дахин хянан үзэх ёстой, мөн хэд хэдэн хувилбар байгаа тохиолдолд хамгийн бага хязгаарлалттайг нь хэрэглэвэл зохино¹³. Хорио цээрийн дэглэм болон тусгаарлах арга хэмжээг аюулгүй, хүндэтгэлтэй байдлаар хэрэгжүүлэх ба эрхээ бүрэн дүүрэн эдлэхэд учирч болох эрсдэлийг анхаарч үзэх ёстой. Олон нийтийн итгэлцэл, хамтын ажиллагааг нэмэгдүүлэхийн тулд нөлөөлөлд өртсөн хүмүүсийн нэр төрд хүндэтгэлтэй хандаж, тэдэнд өөрсдийнхөө амьдралд хяналт тавих бололцоог боломжийн хэрээр олгох, хөл хөдөлгөөнийг нь хязгаарлах арга хэмжээг боломжтой бол сайн дурын байдлаар хэрэгжүүлбэл зохино. Хэрвээ хорио цээрийн дэглэм хэрэгжүүлэх шаардлагатай бол, засгийн газрын зүгээс үүнийг олон улсын хүний эрхийн холбогдох хэм хэмжээний дагуу, ялангуяа, уг дэглэмд хамрагдсан хүмүүст хүнлэг байдлаар хандах нөхцөлийг бүрдүүлж, үр дүнтэй хяналт шалгалтын системийг бий болгох үүрэгтэй. Хорио цээрийн дэглэмд байгаа хүмүүсийн эрхийг хүндэтгэж, хамгаалах ёстой ба үүнд, зохистой орон байр, хоол хүнс, ус, ариун цэврийн байгууламж зэрэг хүний үндсэн хэрэгцээгээр хангагдах эрх багтана. Ковид-19 вирусийн халдварын эсрэг авч буй хорио цээрийн дэглэм болон иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлаж буй аливаа арга хэмжээний үеийн бүхий л шийдвэрт эдгээр зарчмыг баримтлах ёстой.

АЯЛЛЫН ХОРИГ БА ХЯЗГААРЛАЛТ

Аялал жуулчлалд хязгаарлалт хийх ба хориг тавих зэрэг төрөөс хэрэгжүүлдэг бусад хариу арга хэмжээ нь аливаа улсыг орхин явах, мөн өөрийн эх орондоо эргэн ирэх эрхээ дур зоргоор зөрчүүлэхгүй байх зэрэг чөлөөтэй зорчих эрхээ эдлэхэд нөлөө үзүүлдэг.¹⁴ Хэд хэдэн улс хилээ хаасан,¹⁵ мөн Ковид-19 вирусийн тархалт их улсаас¹⁶ гарах болон тухайн улс руу зорчих хөдөлгөөнд хориг тогтоосон нь хүмүүсийн гэр бүлийнхэнтэйгээ харилцах,¹⁷ тогтмол эрхэлдэг ажлаа хийх, хичээл сургуульдаа явахад нь бэрхшээл учруулж байна. Энэхүү арга барилын учруулах эрсдэлээс шалтгаалан ДЭМБ-ын зүгээс тодорхой нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд аяллын болон худалдааны хориг тавихгүй байхыг зөвлөдөг. Хамгийн сүүлд гарсан удирдамжид дурдсанаар “хязгаарлалт нь шаардлагатай тусламж, техникийн туслалцаанд саад болж, бизнесийг тасалдуулж, өвчлөл гарсан улс орнуудын нийгэм, эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай”, цаашлаад “олон нийтийн эрүүл мэндийн онцгой байдал үүссэн үед бараа бүтээгдэхүүн болон хүмүүсийн хөдөлгөөнийг хязгаарлах нь ихэнхдээ үр дүнгүй ба хөндлөнгийн бусад тусламжаас нөөцийг холдуулж болзошгүй юм”.¹⁸

ИУТЭОУП-д заасны дагуу, хууль тогтоомжид заасан, мөн олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах шаардлагын дагуу, хязгаарлагдмал нөхцөл байдалд, тодорхой үндэслэлтэйгээр (дээрхийг үз) зорчих хөдөлгөөнийг хязгаарлаж болно.¹⁹ Аяллын хориг болон хязгаарлалтыг хэрэгжүүлэх тохиолдолд, тэдгээр нь ИУТЭОУП-д заагдсан үүргүүдтэй нийцсэн, дээр дурдсан Сиракусын зарчимд тайлбарласны дагуу ялгаварлан гадуурхалтгүй, хууль ёсны, нэн шаардлагатай бөгөөд тулгамдсан асуудалтай тэнцэхүйц, өөрөөр хэлбэл хамгийн бага хязгаарлалтын хэлбэр байх ёстой юм.

¹¹ Сиракусын зарчим, 28-р зүйл.

¹² ЭЗНСЭОУП, Ерөнхий санал зөвлөмж №14, 28-р хэсэг.

¹³ ЭЗНСЭОУП, Ерөнхий санал зөвлөмж №14, 29-р хэсэг.

¹⁴ ИУТЭОУП, 12-р зүйл

¹⁵ БиБиСи, *Коронавирус: Иран улс халдварын эсрэг ямар арга хэмжээ авч байна вэ?* 2020 оны 3 сарын 2, www.bbc.co.uk/news/world-middle-east-51642926

¹⁶ Улс орнуудын хэрэгжүүлж буй аяллын хориг болон хязгаарлалтыг эндээс үз. www.iatatravelcentre.com/international-travel-document-news/1580226297.htm

¹⁷ Чанел Ньюс Эжиа, *Ковид-19-ийн аяллын хоригоос болж Өмнөд Солонгосчууд гадаадад саатаад байна.* 2020 оны 2 сарын 25, www.channelnewsasia.com/news/asia/covid-19-coronavirus-travel-bans-trap-south-koreans-abroad-12469894

¹⁸ ДЭМБ, *Ковид-19 вирусийн халдвартай холбогду олон улсын тээвэрт ДЭМБ-ийн өгөх шинэчилсэн зөвлөмж*, 2020 оны 2 сарын 29, www.who.int/ith/2019nCoV_advice_for_international_traffic_rev/en/

¹⁹ ИБУТЭОУП, 12,3-р зүйл

МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖ, ИЛ ТОД БАЙДАЛ БА ЦЕНЗУР

ИУТЭОУП-ын 19-р зүйл нь “бүх төрлийн мэдээлэл болон үзэл санааг эрж хайх, хүлээн авах, түгээх” эрхийг хамгаалдаг бөгөөд энэхүү эрхийг зөвхөн тодорхой нөхцөлд, түүний дотор олон нийтийн эрүүл мэндийн ашиг сонирхлын үүднээс хязгаарлаж болно. Улс орнууд ийм хязгаарлалтыг хийхээр болбол, дээр дурдсанчлан ИУТЭОУП болон ЭЗНЭСТОУП-д заагдсан хамгаалалтууд хэрэгжих ёстой. Эрүүл мэндтэй холбоотой мэдээллийг олж авах боломж нь эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн бас нэгэн чухал хэсэг мөн. “Халдвараас урьдчилан сэргийлэх болон хянах арга хэлбэрийг оролцуулан олон нийтийн эрүүл мэндэд тулгамдаж буй асуудалтай холбоотой мэдлэг, боловсролыг хүртээмж”-тэй олгох нь эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн цөм болсон “нэн тэргүүнд авч хэрэгжүүлбэл зохих” үүрэгт тооцогдоно.²⁰ Мэдээллийн хүртээмжтэй байдал нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үндсэн хэмжүүр бөгөөд “эрүүл мэндийн асуудалтай холбоотой мэдээллийг хайх, олж авах, хэлэх, илэрхийлэх эрхэд” мөн хамаарна.²¹ Өвчилсөн бүх хүн, олон нийтийн эрүүл мэндэд тулгарч буй аюулын мөн чанар, хэр хэмжээ, эрсдэлийг бууруулахын тулд авах боломжит арга хэмжээ, цаашид гарч болзошгүй үр дагаврын талаар сэрэмжлүүлэг эрт өгөх, мөн авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээний талаар хялбар, хүртээмжтэй, цаг үеийн, ач холбогдол бүхий мэдээлэл авах эрхтэй. Мэдээлэл нь өвчилсөн хүмүүсийн ялгаатай хэрэгцээ шаардлагыг хангасан хэлээр, мэдээллийн хэрэгсэл болон хялбархан ойлгогдох, хүртээмжтэй бусад хэлбэртэй байх ба энэ нь хүмүүсийг бүрэн хамруулах, мөн тэдэнд хариу арга хэмжээний үед мэдээлэлтэйгээр шийдвэр гаргах боломжийг олгоно.

Вирусийн тархалтыг тогтоон барих, эмнэлгийн тусламж үйлчилгээ шаардлагатай байгаа хүмүүст туслах болон нөөцийг үр дүнтэй зарцуулахад итгэлцэл нэн чухал юм. Гэхдээ, олон нийтийн тэрхүү итгэлийг олж авахын тулд, цаг тухайд нь холбоо барьж, эрүүл мэндийн тулгамдсан асуудлын мөн чанарыг ойлгох боломжит бүхий л мэдээллийг өгөх шаардлагатай. Боломжтой бол, үүнийг олон нийтийн оролцоо болон орон нутгийн засаг захиргаатай түншлэх замаар хэрэгжүүлбэл зохино. Хэрвээ ингэж чадахгүй бол хүмүүсийн арга барагдах, уурлаж бухимдах байдал нэмэгдэж, олон нийтийн эрүүл мэндийн талаар авч буй арга хэмжээг сулруулж, бусдыг эрсдэлт оруулж, хүний эрхийг зөрчиж болзошгүй. Улс орнуудын Ковид-19 халдварын эсрэг авч буй арга хэмжээний талаарх мэдээлэл хязгаарлагдмал, ил тод бус, цензуртэй байгаа тохиолдолд тэд дээр дурдсан эрхүүдийг зөрчих эрсдэлтэй юм.²² Түүнчлэн хүмүүсийг халдвар авахаас өөрсдийгөө хамгаалахад шаардлагатай арга хэмжээ авах, бүхий л оролцогч талууд бодит байдлын талаар ойлголттой болох, мөн вирусийн халдвартай тэмцэх үр дүнтэй арга хэмжээ авах, хамтран ажиллахад бэрхшээлтэй байдал бий болгох эрсдэлтэй.

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУСЛАМЖ, БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

Эрүүл мэндтэй холбоотой эрхэд “халдварт өвчин, тухайн орон нутгийн өвчин, мэргэжлээс шалтгаалах болон бусад өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, хянах” зэрэг багтдаг.²³ Халдварт өвчин тархаж байгаа үед уг эрхийн хүрээнд урьдчилан сэргийлэх тусламж үйлчилгээ, бараа бүтээгдэхүүн болон мэдээллийг бүх хүнд хүртээмжтэй хүргэх төрийн үүрэг хамаарна. Үүнд хүмүүст өөрсдийгөө хэрхэн хамгаалах талаар хүртээмжтэй, үнэн зөв, нотолгоотой мэдээллийг түгээх, мөн урьдчилан сэргийлэхэд шаардлагатай аливаа бараа бүтээгдэхүүнийг боломжийн үнээр олж авах боломжийг бүх хүмүүст олгох зэрэг багтана. Зарим оронд ариутгагч, маск зэрэг урьдчилан сэргийлэх бүтээгдэхүүний хомсдол бий болсон талаар хэд хэдэн мэдээлэл байна.²⁴ Орон нутгийн нийгэмлэг /SoCo/ нэртэй ТББ-ын мэдээнд, Хонг-Конгийн орлого багатай өрхүүдийн бараг 70% нь маск болон ариутгалын бодис зэрэг урьдчилан сэргийлэх хэрэгсэл худалдан авч хүчрэхгүй байгааг онцолжээ.²⁵ Эдгээр хэрэгслийг хэрэглэхийг зөвлөж байгаа нөхцөлд боломжийн үнэтэй, хүртээмжтэй байлгах нь төрийн үүрэг юм. Энэхүү баримт бичгийг боловсруулж байх үед дэлхийн

²⁰ ЭЗНСЭОУП, Ерөнхий санал зөвлөмж №14, 44-р зүйл

²¹ ЭЗНСЭОУП, Ерөнхий санал зөвлөмж №14, 126-р зүйл

²² Волл Стрит Журнал, Ираний удирдагчид коронавирусийн халдварыг бууруулсан гэдэгт үндэстэн даяараа эргэлзэж байна. 2020 оны 2 сарын 28, www.wsj.com/articles/as-irans-leaders-contradict-coronavirus-doubts-emerge-over-national-tally-11582903223; *Коронавирусийн талаарх худал мэдээлэл нь Хятадын засгийн газарт бэрхшээл учруулж байна.* 2020 оны 3 сарын 2, edition.cnn.com/2020/03/01/asia/china-coronavirus-truth-rumors-intl-hnk/index.html

²³ ЭЗНСЭОУП, 12.2-р зүйл

²⁴ БиБиСи, *Коронавирус: Иран улс халдвартай хэрхэн тэмцэж байна вэ? 2020 оны 3 сарын 2*, www.bbc.co.uk/news/world-middle-east-51642926

²⁵ Өмнөд Хятадын Өглөөний Мэдээ, *Коронавирус: Хонг-Конгийн орлого багатай өрхүүд маск болон ариутгалын бодис авч дийлэхгүй зүдэрч байгааг шинэ судалгаа харууллаа, 2020 оны 2 сарын 23*,

100 гаруй оронд тархаад байгаа Ковид-19 вирусийн халдвар нь илүү олон улс, бүс нутагт тархах бодит аюултай байна. Олон улс орон уг вирусийн тархалтад үр дүнтэй хариу арга хэмжээ авах нөөц, эрүүл мэндийн системийн хүчин чадлын хувьд мөхөс байна. Эрүүл мэндээ хамгаалуулах эрхэд олон улсын хамтын ажиллагаа, туслалцаа үзүүлэх үүрэг мөн хамаардаг (дор дурдсаныг үз). Арга хэмжээ авах техникийн болон санхүүгийн чадавхтай улс өөрийн боломжоор хомс улс орнуудад халдварт өвчний дэгдэлтээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд нь туслалцаа үзүүлэх ёстой.

ОНЦГОЙ НӨХЦӨЛ, ОНЦ БАЙДЛЫН ҮЕ

Олон нийтийн эрүүл мэндэд үүсээд байгаа онцгой нөхцөл байдлын улмаас улс орнууд онц байдал зарлах бүрэн эрхээ хэрэгжүүлэх шаардлага гарч болно. Хэрэв нөхцөл байдал ард иргэдийн амь насанд аюул занал учруулж (жишээ нь, тухайн өвчин онц халдвартай, хүндрэлийн зэрэг өндөртэй, ялангуяа өвчлөл өндөр, эсвэл цаашид тархах эрсдэлтэй) байгаа бол төрийн зүгээс олон улсын эрх зүй болон холбогдох хэм хэмжээнд нийцүүлэн онц байдал зарлах боломжтой.²⁶ Онцгой байдлын зэрэг нь үүссэн нөхцөл байдалд нэн яаралтай авч хэрэгжүүлэх шаардлага болон “цаг хугацаа, хамрах хүрээ, шаардагдах нөөцийн хэмжээ, мөн онцгой байдлын улмаас саатуулагдсан аливаа арга хэмжээнээс хамаарч” тодорхой хязгаартайгаар хэрэгжих ёстой.²⁷ Хамгаалах бүхий л арга хэмжээ нь олон улсын эрх зүйг нягт баримталсан байх ёстой ба үүнд, онцгой байдал зарлаж байгаагаар албан ёсоор мэдээлэх, энэ хүрээнд авч буй арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлж буй учир шалтгааны тодорхой тайлбарын хамт олон улсын хэмжээнд мэдэгдэх, арга хэмжээ нь түр зуурын байх, мөн хугацааг сунгахын өмнө тогтмол, бодит дүн шинжилгээ хийгдэхээр байх, олон улсын эрх зүйгээр хүлээн зөвшөөрөгдсөн, энэ тохиолдолд хүний эрхийн зайлшгүй шаардлагатай хязгаарлалтыг багасгах зэрэг багтана.

ХАЛДВАР АВСАН ХҮМҮҮСТ ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ БА ҮНИЙН БОЛОМЖИТ БАЙДАЛ

Ковид-19 халдварын эсрэг вакцин болон эм гаргаж авахаар ажиллаж байгаа, ойрын хугацаанд хэрэглэх боломжгүй байгаа хэдий ч халдвар авсан, халдварын сэжигтэй хүмүүс оношлуулах, шаардлагатай тохиолдолд вирусийн шинж тэмдэг, үр дагаврыг зохицуулах, дэмжих үйлчилгээ зэрэг эмнэлгийн тусламж үйлчилгээ шаардлагатай хэвээр байна. Саяхан хийгдсэн нэгэн судалгаанд Ковид-19 вирусийн халдвартай холбоотой нас баралт нь эмнэлгийн тусламж үйлчилгээний нөөцийн хүртээмжтэй холбоотой болохыг тэмдэглэжээ.²⁸ Өөрөөр хэлбэл, эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжгүй байдлын улмаас Ковид-19 вирусийн халдвар хүмүүсийн эрүүл мэндэд ноцтой үр дагавар үүсгэж байна.²⁹ Ийм нөхцөл байдалд орлого багатай, алслагдсан бүс нутагт оршин суудаг, мөн нийгмээс гадуурхагдсан бүлгийн хүмүүс шаардлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээг авахад ихээхэн бэрхшээлтэй тулгарч магадгүй юм.

Эрүүл мэндтэй холбоотой эрхийн хүрээнд эрүүл мэндийн байгууламж, тусламж үйлчилгээ, эм, эмнэлгийн хэрэгсэл, Ковид-19 вирусийн халдварын эсрэг ирээдүйд гарах аливаа вакцин болон эмчилгээ, тэдгээрийн хүртээмж нь улс орны хэмжээнд хангалттай байх, хүн бүр ялгаваргүйгээр хүртэх боломжтой байх, анагаахын ёс зүйг хүндэтгэсэн, соёлын хувьд зохистой, шинжлэх ухаан болон эмнэл зүйн хувьд тохиромжтой, сайн чанартай байх зэрэг хамаарна.³⁰ “Хүртээмжтэй байдал” гэдэгт эдгээр бүтээгдэхүүн,

www.scmp.com/news/hong-kong/health-environment/article/3051968/coronavirus-hong-kongs-low-income-families

²⁶ ИУТЭОУП, 4-р зүйл, Америкийн хүний эрхийн конвенцийн 27-р зүйл, Европын хүний эрхийн конвенцийн 15-р зүйл, мөн Хүний эрхийн хорооны Ерөнхий санал зөвлөмж №29 Онц байдлын үе 4-р зүйл зэргийг үз. НҮБ-ын бичиг баримт. ССРР/С/21/Rev.1/Add.11 (2001).

²⁷ Хүний эрхийн хороо, Ерөнхий санал зөвлөмж №29, Онц байдлын үе 4-р зүйл, НҮБ-ын бичиг баримт. ССРР/С/21/Rev.1/Add.11 (2001), para 4.

²⁸ Юнпэнг Жи, Жонгрэн Ма болон бусад. “Ковид-19 вирусийн эндэгдэл ба эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийн харилцан хамаарал”, 2020 оны 2 сарын 25, [www.thelancet.com/journals/langlo/article/PIIS2214-109X\(20\)30068-1/fulltext](http://www.thelancet.com/journals/langlo/article/PIIS2214-109X(20)30068-1/fulltext)

²⁹ ДЭМБ-ын зүгээс ч мөн дэлхийн хамгийн ядуу хүн ам “хумхаа, ХДХВ болон ДОХ, сүрьеэ зэрэг хамгийн аюултай гурван халдварт өвчинд” маш ихээр нэрвэгддэгийг сануулаад, “нас, хүйс, бэлгийн болон жендэрийн чиг хандлага, дүрвэгч зэрэг байдлаас шалтгаалсан тэгш бус байдал нь олон тохиолдолд өвчний байдлыг дордуулдаг болохыг” анхааруулсан байна. ДЭМБ, Хүний эрх ба эрүүл мэнд - Fact Sheet, 29 2017 оны 12 сар, www.who.int/mediacentre/factsheets/fs323/en/

³⁰ ЭЗНСЭОУП, Ерөнхий санал зөвлөмж №14, 12-р зүйл

үйлчилгээ нь нэн эмзэг, хүн амын гадуурхагдсан хэсэгт болон бүхий л хүн амд аюулгүй, боломжийн үнээр хүрэх боломжтой байхыг ойлгоно. “Хүртээмжтэй байдал”-д эрүүл мэндтэй холбоотой мэдээллийн хүртээмж мөн хамаарна.

Эрүүл мэндтэй холбоотой эрхэд бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндийн аль аль нь хамаатай. Улс орнууд Ковид-19 вирусийн халдвар болон халдварыг тогтоон барих арга хэмжээний үеийн сэтгэл гутрал, түгшүүр зэрэг сэтгэцийн эрүүл мэндийн болзошгүй үр дагаварт нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх боломжтой байх ёстой. Вирусийн халдвартай, халдвар авсан гэж сэжиглэгдэж буй болон, халдвар авсан нь тогтоогдсон хүмүүс, тэдний гэр бүлийнхэн тохирох зөвлөгөө авах, өөрсдийнхөө хэргийг боломжит хамгийн дээд хэмжээнд өөрсдөө зохицуулах боломжийг эдлэх эрхтэй.

Улс орнууд Ковид-19 вирусийн халдварын эсрэг гаргаж авсан аливаа вакцин, эмчилгээг бүх хүнд хүртээмжтэй, үнийн хувьд боломжийн байлгах ёстой. Үүний тулд улс орнууд (эм үйлдвэрлэгч компаниуд зэрэг) чухал ач холбогдолтой оролцогч талуудтай хамтран ажиллахын хамт бүхий л оролцогч талууд хүний эрхийг сахин хамгаалах үүргээ биелүүлэх ёстой.³¹ Түүнчлэн, Ковид-19 вирусийн халдварын тархалтаас үр дүнтэй урьдчилсан сэргийлэхэд нэн чухал зүйл болох ус болон ариун цэврийн байгууламжтай байх эрхээ эдлэх боломжийг нэн тэргүүнд тавьж, хүчин чармайлтаа хурдавчилбал зохино.³²

ЗАРИМ БҮЛГИЙНХЭНД ТУСАХ ОНЦГОЙ БОЛОН ТЭГШ БУС НӨЛӨӨЛӨЛ

Хэн ч Ковид-19 вирусийн халдвар авах боломжтой, гэхдээ тодорхой бүлгийн хүмүүс хүндээр өвчлөх, амь насаа алдах ихээхэн эрсдэлтэй байна. ДЭМБ-ын мэдээлснээс үзэхэд, өндөр настнууд болон хууч өвчтэй (багтраа, чихрийн шижин, зүрх судасны өвчин зэрэг) хүмүүст уг вирусийн халдвар хүндрэл үзүүлэхээр харагдаж байна.³³ Ковид-19 вирусийн халдварын жендэрийн нөлөөллийн талаарх мэдээлэл одоогийн байдлаар хомс байгаа хэдий ч өмнө нь тохиолдож байсан нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед охид, эмэгтэйчүүдэд онцгой, тэгш бус байдлаар нөлөөлж байжээ.³⁴ Энэ байдал нь ихэвчлэн эрүүл мэнд, нийгмийн болон албан бус салбарын аль алинд халамж үйлчилгээ үзүүлэх үүрэг гүйцэтгэж байсан эмэгтэйчүүдтэй холбогдох³⁵ ба өвчний халдвар авах өндөр эрсдэлтэй нөхцөлд, түүнчлэн, эрүүл мэндийн туслалцаа хүсэх болон шийдвэр гаргах үйл явцын эргэн тойронд жендэрийн тэгш бус байдалтай нүүр тулгарч байжээ.³⁶ Охид, эмэгтэйчүүд болон аль нэг хүйст хамаардаггүй хүмүүсийн эрхийг хамгаалах, тэдэнд шаардлагатай дэмжлэгийг үзүүлэхийн тулд халдварт өвчний эсрэг авч буй бүхий л хүчин чармайлтанд жендэрийн дүн шинжилгээ хийвэл зохино. Энэхүү шинжилгээ нь тэдний эрүүл мэнд, аюулгүй байдал болон холбогдох хүний эрхэд учирч болзошгүй аюулыг илрүүлж, тэдгээрийг бууруулах ёстой. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдээлэл, үйлчилгээний хүртээмж, тухайлбал, сарын тэмдэгийн үеийн эрүүл ахуйн бүтээгдэхүүн, жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг шаардлагатай хэрэгслээр хангах зэргээр охид, эмэгтэйчүүдийн онцгой хэрэгцээ шаардлагыг анхааралдаа авах ёстой.

Үүнээс гадна, зарим хүмүүс вирусийн халдвараас өөрсдийгөө хангалттай хэмжээнд хамгаалахад нэмэлт саад бэрхшээлтэй тулгарч байж болзошгүй, тухайлбал, ядуу хүмүүс маск, ариутгалын бодис зэрэг урьдчилан сэргийлэх хэрэгсэл олж авахад хүндрэлтэй, мөн орон гэргүй хүмүүс өөрсдийгөө тусгаарлахад томоохон бэрхшээлтэй учирна. Үүний нэгэн адилаар, ус болон аюулгүй ариун цэврийн байгууламжгүй хүмүүс Ковид-19 вирусийн халдвар авах илүү эрсдэлтэй ба байнга зөвлөж буй урьдчилан сэргийлэх арга хэмжээг (гараа тогтмол угаах зэрэг) авахад бэрхшээлтэй байх болно. Урьдчилан сэргийлэх хангалттай арга

³¹ Хүн бүр бие махбод болон сэтгэцийн эрүүл мэндийн хамгийн дээд түвшин байх эрхийн талаарх Тусгай илтгэгчийн тайлан, Эм үйлдвэрлэгч компаниудад зориулсан эмийн хүртээмжтэй холбоотой Хүний эрхийн удирдамж, НҮБ-ын баримт бичиг, А/63/263 (2008), www.who.int/medicines/areas/human_rights/A63_263.pdf

³² Ус болон ариун цэврийн байгууламжтай байх эрхийг амьжиргааны зохистой түвшинд амьдрах эрхийн нэг хэсэг гэж үздэг (ЭЗНСЭОУП-ын 11-р зүйл) ба уг Пакт болон хүний эрхийн бусад баримт бичгүүдэд агуулга нь тусгагдсан байдаг, Эмнести Интернэшл, Хүний нэр төртэй байх эрхийг үз. (Index: POL 34/001/2014), хууд. 50-53.

³³ ДЭМБ, Коронавирусийн халдвар (Ковид-19) олон нийтэд өгөх зөвлөмж: Цуу яриаг няцаах нь (2020), www.who.int/emergencies/diseases/novel-coronavirus2019/advice-for-public/myth-busters

³⁴ НҮБХАС, Шинэ Эбола вирусийн халдвар Ардчилсан Конго улсын охид, эмэгтэйчүүдэд хүндээр тусч байна, 2018 оны 9 сарын 10, www.unfpa.org/news/newebola-outbreak-hits-women-and-girls-hardest-democratic-republic-congo

³⁵ ДЭМБ-ын судалгаагаар эрүүл мэнд болон нийгмийн салбарын ажилтнуудын 70%-ийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг байна. ДЭМБ, Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний жендэрийн тэгш байдал: 104 орны дүн шинжилгээ, Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний тайлан мэдээлэл 1, https://www.who.int/hrh/resources/gender_equality_health_workforce_analysis/en/;

³⁶ Клэйр Вэнхам, Жулиа Смит болон бусад, Ковид-19: халдварын жендэрийн нөлөөлөл, Лансет, 2020 оны 3 сарын 6, The Lancet, [www.thelancet.com/journals/lancet/article/PIIS0140-6736\(20\)30526-2/fulltextWenham](http://www.thelancet.com/journals/lancet/article/PIIS0140-6736(20)30526-2/fulltextWenham)

хэмжээ авах боломжгүй, хорих анги³⁷ болон эрүүл мэндэд хөнөөл учруулах эрсдэлтэй орчинд бусадтай хамт ажиллах, амьдрахаас өөр сонголтгүй нөхцөлд байгаа хүмүүс тухайлан халдварт өртөх эрсдэлтэй.

Орлого багатай хүмүүс болон баталгаагүй, албан бус хөдөлмөр эрхлэгчид халдварт өвчний эдийн засагт үзүүлэх улам бүр өсөн нэмэгдэж буй сөрөг нөлөөллөөс болж орлого нь багасах, ажилгүй болох зэргээр илүү ихээр өртөж болзошгүй.³⁸ Ковид-19 вирусийн халдварын эсрэг хариу арга хэмжээг төлөвлөхдөө улс орнууд уг вирусийн тодорхой бүлэг хүмүүст үзүүлэх нөлөөллийг ухамсарлаж, төлөвлөгөө, стратегитаа тэдний хэрэгцээ шаардлага, амьдралын туршлагыг бүрэн дүүрэн тусгахад анхаарах ёстой.

Ковид-19 вирусийн тохиолдол нэмэгдэх нь нийгмийн эрүүл мэндийн тогтолцоонд ихээхэн дарамт учруулах магадлалтай ба хууч өвчтэй хүмүүс, өндөр настнууд болон жирэмсэн эмэгтэйчүүд зэрэг уг вирусээс хамааралгүйгээр, эрүүл мэндийн тогтмол тусламж үйлчилгээ шаардлагатай байдаг хүмүүст сөргөөр нөлөөлж болзошгүй байна³⁹. Жишээ нь, эрүүл мэндийн ажилтнууд мөн шаардлагатай нөөцийг Ковид-19 вирусийн халдварын хариу арга хэмжээнд илүүтэй чиглэгдэх болсноос Хятад улсад эмэгтэйчүүд жирэмсний хяналт болон эмнэлгийн чанартай үйлчилгээ авахад бэрхшээлтэй байгааг тайлан мэдээнүүдэд дурджээ.⁴⁰ Өндөр настнууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хэдийгээр уг вирусийн нөлөөлөлд шууд өртөөгүй байсан ч илүү тусгаарлагдсан мэт мэдрэмж авах, мөн Ковид-19 вирусийн халдварын үед хэрэгжүүлж буй нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээн нь илүүтэй бэрхшээл үүсгэж байж болзошгүй.⁴¹ Улс орнууд нэн тэргүүнд хүмүүс хэрэгцээтэй бараа, үйлчилгээгээр хангагдаж байгаа эсэхийг мэдэхийн тулд судалгаа явуулах хэрэгтэй. Ерөнхийдөө, Ковид-19 вирусийн халдварын эсрэг хариу арга хэмжээ авах болон бэлтгэхдээ улс орнууд эдгээр арга хэмжээний эрүүл мэндийн систем болон эрүүл мэндийн бусад шалтгаанаар эмнэлгийн тусламж үйлчилгээ шаардлагатай хүмүүст, мөн аливаа сөрөг нөлөөллийг бууруулахад анхаарал тавих шаардлагатай юм.

НИЙГМИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА АЖИЛЧДЫН ЭРХ

Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор аяллын хориг, хорио цээрийн дэглэм болон хүмүүсийн олноор цуглахыг хязгаарлах зэрэг хэд хэдэн арга хэмжээ авч байгаа нь хүмүүсийн хөдөлмөрлөх эрхэд, ялангуяа баталгаагүй хөдөлмөр эрхэлдэг хүмүүст тэгш бус, сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй. Үүнд, цагаач ажилчид,⁴² түр зуурын, цагийн ажил хийдэг хүмүүс (gig economy)⁴³ зэрэг албан бус хэлбэрээр ажилладаг хүмүүс хамаарна. Эдгээр салбарт ажилладаг хүмүүс ихэнхдээ хангалттай хэмжээний, эсвэл ямар ч нийгмийн хамгааллын тэтгэмж авдаггүй ба хорио цээрийн дэглэмийн үед цалингүй болдог эсвэл цалинтай чөлөө олддоггүй. Тэд өвчний халдвар авсан тохиолдолд оношлуулах, эмчилгээ хийлгэхэд ч нэмэлт саад бэрхшээлтэй тулгарч болзошгүй. Ковид-19 вирусийн халдвараас шалтгаалан хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа тохиолдолд, мөн бүх хүн цалинтай чөлөө, өвчтөн асрах болон хүүхэдтэй болсны чөлөө эдлэх зэргээр нийгмийн хамгаалалд бүрэн хамрагдах боломжийг улс орнууд баталгаажуулах ёстой.⁴⁴ Үүнд жишээ нь, өөрсдөө өвчтэй, хорионд орсон, эсвэл сургууль хаагдсанаас болж хүүхдээ харж байгаа

³⁷ Жишээ болгож: Английн Эмнести Интернэшнл, *Иран: Коронавирусийн айдас дунд Назанин Загхари-Ратклиффийг ямар ч болзошгүйгээр суллах болов*, Хэвлэлийн мэдээ, 2020 оны 3 сарын 3-г үз, www.amnesty.org.uk/press-releases/iran-amid-coronavirus-fears-nazanin-zaghari-ratcliffe-should-be-released

³⁸ Өмнөд Хятадын Өглөөний Мэдээ, *Бид хэрхэх вэ?* 2020 оны 2 сарын 26, www.scmp.com/news/hong-kong/hong-kong-economy/article/3052526/what-about-us-needy-hong-kong-who-fall-short-mark

³⁹ Үндэсний олон нийтийн радио, *Хэрвээ Хятадад хүндээр өвдсөн бол танд юу тохиолдох вэ? – Гэхдээ тэр нь Коронавирус биш*, 2020 оны 2 сарын 25, www.npr.org/sections/goatsandsoda/2020/02/25/805712259/what-happens-if-youre-critically-ill-in-china-but-not-with-coronavirus

⁴⁰ Нью Йорк Таймс, *"Би уйлмаар байна: Коронавирус жирэмсэн эхчүүдийг түгшээж байна"*, www.nytimes.com/2020/02/25/business/coronavirus-china-pregnant.html; нөхөн үржихүйн эрүүл мэндийн нөөц яаралтай тусламж руу чиглэснээр эхийн эндэгдэл хамгийн өндөр байдаг бүс нутагт энэ тоог улам нэмэгдүүлж байна.

⁴¹ Өмнөд Хятадын Өглөөний Мэдээ, *Коронавирусийн халдварын үед Хонг-Конгийн ганц бие өндөр настнуудыг тусгаарлалт, сэтгэл түгших зэрэг томоохон аюул хүлээж байна*. 2020 оны 2 сарын 29, www.scmp.com/news/hong-kong/health-environment/article/3052694/amid-coronavirus-outbreak-bigger-killers-lurk

⁴² Аль Жазийра, *Коронавирусийн халдвар: Цагаач ажилчид хэрхэх вэ?* 2020 оны 3 сарын 5, www.aljazeera.com/news/2020/03/coronavirus-outbreak-migrantworkers-do-200305102831177.html

⁴³ Гардиан-г жишээ болгон үз. *"Хэрвээ би корона вирусийн халдвар авбал би сүйрнэ, албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчид өвчний зардлыг дийлэхгүй"*. 2020 оны 3 сарын 7, www.theguardian.com/world/2020/mar/07/gig-economy-workers-on-breadline-too-poor-to-stay-at-home-if-they-catch-coronavirus; БиБиСи: *"Өвчин тусвал би ажиллах хэрэгтэй болно"*, 2020 оны 3 сарын 9, www.bbc.co.uk/news/business-51800050

⁴⁴ Илүү дэлгэрүүлж ЭНЦЭХ-ны Ерөнхий санал зөвлөмж №19, Нийгмийн хамгаалал авах эрх (9-р зүйл)-г үз, НҮБ-ын баримт бичиг. E/C.12/GC/19 (2008).

хүмүүс хамаарна. Үүнээс гадна (хөдөлмөр эрхлэх боломжгүй үедээ) нийгмийн хамгааллын дэмжлэг авах эрхийг хүндэтгэн, эдгээр арга хэмжээг авах нь төрөөс хэрэгжүүлж буй нийгмийн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг үр дүнтэй дагаж мөрдөхөд хүмүүст дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой. Тухайлбал, хэрвээ нийгмийн хамгааллын хангалттай дэмжлэг авах боломжтой бол хүмүүс өөрсдөдөө сөрөг үр дагавар учруулахгүйгээр хорио цээрийн дэглэмийг дагаж мөрдөх болно.

ГУТААН ДОРМЖЛОХ БА ЯЛГАВАРЛАХ ЯВДЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

Ковид-19 вирусийн халдварын тархалтаас үүдэн зарим нэгэн улс үндэстнээс гаралтай гэгдэх хүмүүсийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлох явдал гарч байгаа талаар хэд хэдэн мэдээлэл байна. Жишээ нь, зарим улсад Хятад рестораниуд хаалгаа барихад хүрч байгаа⁴⁵ бол зарим улсад зочид буудал болон ресторанд үйлчлүүлж байсан хүмүүс Хятад үйлчлүүлэгчдээс зай барих, зугтаах болжээ.⁴⁶ Зарим улсад Зүүн Азиас гаралтай гэж үзэж байгаа хүмүүсийг дарамтлах, арьс өнгөөр ялгаварлах, бие махбодод нь халдах эрсдэл өндөр байна.⁴⁷

Хүний эрхийн хэд хэдэн баримт бичгүүдэд⁴⁸ тусгагдсан тэгш байдал, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмууд нь бүхий л засгийн газруудын Ковид-19 вирусийн халдварын эсрэг авч буй хариу арга хэмжээний анхаарлын төвд байх ёстой. Ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх нь олон улсын эрх зүйгээр хамгаалагдсан, хүн бүрийн эдлэх учиртай нэн тэргүүний, ихээхэн чухал эрх юм. ЭЗНСЭХ-ны 20-р Ерөнхий санал зөвлөмжид зааснаар, хүнийг эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлахыг хориглоно, хүн эрүүл мэндийн тухайн үеийн болон ирээдүйн байдлаасаа болж ЭЗНСЭОУП-аар хамгаалагдсан эрхээ эдлэхэд нь саад болохгүй байх явдлыг улс орнууд баталгаажуулах ёстой. Мөн улс орнууд хүнийг эрүүл мэндийн байдлаас (одоогийн болон ирээдүйн) нь шалтгаалан гутаан доромжлох явдал их байгаа нь тэдний эрхээ эдлэх боломжийг дордуулж болзошгүй тул анхааралдаа авч, арга хэмжээ авах ёстой.⁴⁹

Нийгмийн эрүүл мэндийн байгууллагууд ч ийм доромж хандлагын хортой нөлөөллийг тэмдэглэсэн байна. ДЭМБ иймэрхүү доромж хандлага нь нийгмийн эрүүл мэндэд хэрхэн сөрөг нөлөө үзүүлж байгааг тайлбарлахдаа, энэ нь хүмүүс гадуурхагдахаас эмээхдээ өвчнөө нуун дарагдуулахад хүргэх, эрүүл мэндийн тусламж яаралтай авахад саад учруулах, мөн эрүүл зан үйлийг дагаж мөрдөхөд саад болж байна гэжээ.⁵⁰ АНУ-ын Өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах төвүүд ч мөн “Гадуурхалт, доромжлол нь асуудал үүсгэж буй өвчний оронд энгийн хүмүүст илүүтэйгээр их айдас, уур бухимдлыг үүсгэж, хүн бүрийг зовоож байна” гэж онцолжээ.⁵¹ Улс орнууд бүх хүнийг ийм зүй бус хандлагаас хамгаалах, мөн төрийн болон хувийн хэвшлийнхний хийх үйл ажиллагааг тодорхойлсон бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх зэргээр тодорхой, төлөвлөсөн, зорилтот арга хэмжээнүүдийг авах ёстой.

⁴⁵ СиЭнЭн, *Коронавирусийн халдвараас болж Хятад рестораниуд хаалгаа барьж байна*, 2020 оны 2 сарын 18, edition.cnn.com/2020/02/18/australia/australia-chineserestaurants-coronavirus-intl-hnk-scli/index.html

⁴⁶ Блүмбэрг, *Коронавирусийн үеийн айдас: Хятадуудыг хүлээж авахгүй*, 2020 оны 1 сарын 30, www.bloomberg.com/news/articles/2020-01-30/fear-in-the-age-of-coronavirus-chinese-no-longer-welcome

⁴⁷ Дачрэвю, *Коронавирус: Арьс өнгөөр ялгаварласан утгатай дуу дуулахаа зогсоохыг хүссэнийх нь төлөө Голланд-Хятадын эрлийз эмэгтэйд хэсэг Голланд залуу халджээ*. 2020 оны 2 сарын 24, dutchreview.com/news/coronavirus-dutch-chinese-woman-attacked-over-racist-song/; Өмнөд Хятадын Өглөөний Мэдээ, *Коронавирустай холбож арьс өнгөөр ялгаварласан доромжлолд хариулсных нь төлөө Сингапур оюутанд хэрцгийгээр халдсан байна*. 2020 оны 3 сарын 3, www.scmp.com/news/asia/southeast-asia/article/3064742/singaporean-student-london-bashed-after-responding-racist; Гардиан, Мелбурн хотын эмнэлгийн эмч, сувилагчид коронавирустай үймээний үеэр арьс өнгөөр гадуурхажжээ. 2020 оны 2 сарын 27, www.theguardian.com/world/2020/feb/27/doctors-and-nurses-at-melbourne-hospital-racially-abused-over-coronavirus-panic

⁴⁸ ХЭТТ-ын 1, 2-р зүйл, ЭЗНСЭОУП-ын 2-р зүйл, ИУТЭОУП-ын 2-р зүйл, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай конвенцийн 2-р зүйл, ЭЯГБХУТК-ийн 2-р зүйл, АУЯБХУТОУК-ийн 2-р зүйл, Европын хүний эрхийн конвенцийн 1-р зүйл, Америкийн хүний эрхийн конвенцийн 1-р зүйл.

⁴⁹ ЭЗНСХ-ны Ерөнхий санал зөвлөмж №20, Эдийн засаг, нийгэм, соёлын байдлаар ялгаварлахгүй байх эрх ЭЗНСЭОУП, 2.2-р зүйл, НҮБ-ын бичиг баримт, E/C.12/GC/20 (2009), para. 33.

⁵⁰ ДЭМБ, *Коронавирусийн халдвар 2019 (Ковид-19) Нөхцөл байдлын тайлан-35*, 2020 оны 2 сарын 24, www.who.int/docs/default-source/coronaviruse/situationreports/20200224-sitrep-35-covid-19.pdf?sfvrsn=1ac4218d_2

⁵¹ Өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах төвүүд, *Доромжлол ба тэсч үлдэх нь*, <https://www.cdc.gov/coronavirus/2019-ncov/about/related-stigma.html>

ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНУУДЫГ ХАМГААЛАХ НЬ

Эрүүл мэндийн ажилтнууд халдварт өвчинтэй тэргүүн эгнээнд тэмцэж, өөрсдөдөө болон гэр бүлийнхэндээ учрах эрсдэлийг үл харгалзан хүмүүст үйлчилсээр байгаа билээ. Тэд ажлаа хийж байхдаа Ковид-19 вирусийн халдвар авах, уртасгасан цагаар ажиллаж, сэтгэл зүйгээр хямрах, эцэж ядрах зэрэг эрсдэлтэй нүүр тулж байна.⁵² Эрүүл мэндийн ажилтнуудад тус халдварт өвчний үзүүлэх нөлөөллийг нарийвчлан судалж дуусаагүй байгаа хэдий зөвхөн Хятадад 3000 гаруй эрүүл мэндийн ажилтан уг вирусийн халдвар авсан тухай мэдээлэл байна.⁵³ Эрүүл мэндэд нүүрлэж буй ноцтой асуудлын талаар 2019 оны сүүлээр эхэлж мэдээлсэн ч Хятадын засгийн газраас тэднийг буруушаан, зэмлэл хүртсэн Ли Венлян эмч зэрэг Ковид-19 вирусийн халдвартай өвчтөнүүдийг эмчилж байсан эмч нар амь насаа алдаж байна.⁵⁴

Эрүүл мэндтэй холбоотой эрх нь засгийн газруудаас “үйлдвэрлэлийн осол, өвчлөлийн эрсдэлийг бууруулахын тулд холбогдох үндэсний хөтөлбөрүүдийг тогтмол хугацаанд эргэн хянаж байх, мөн эрүүл мэндийн ажилтнуудын ажиллах орчны асуудлыг багтаасан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үйлчилгээний⁵⁵ холбогдох үндэсний хөтөлбөрийг боловсруулж гаргахыг” шаарддаг. Чанартай, хангалттай хүрэлцээтэй нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, мэдээлэл, сургалт болон сэтгэлзүйн туслалцаа дэмжлэг зэрэг нь бүгд эмч, сувилагч болон хариу арга хэмжээнд ажиллаж буй бусад ажилтнуудыг дэмжихэд шаардлагатай.⁵⁶ Улс орнууд Ковид-19 вирусийн халдвараас шалтгаалж өвчилсөн, нас барсан эрүүл мэндийн ажилтнуудын гэр бүл болон бусад хүмүүст дэмжлэг үзүүлэх механизмыг баталгаажуулах ёстой.

ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА БА ТУСЛАМЖ

Олон улсын хамтын ажиллагаа, туслалцаагүйгээр хүний эрхийг хамгаалах үүргийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй. Хүний эрхийг хангах үүрэг хариуцлагад хүний эрүүл мэндтэй холбоотой эрхэд хүндэтгэлтэй хандах явдал болон олон улсын хамтын ажиллагаа, туслалцаатай холбоотой үүрэг хамаардгийг дэлхийн улс орнуудын дийлэнх олонх нь хүлээн зөвшөөрсөн байдаг.⁵⁷ ЭЗНСЭОУП-ийн Ерөнхий санал зөвлөмж №14-т “тухайн улсын хил хязгаарыг даван, түргэн тархаж буй халдварт өвчний үед олон улсын хамтын нийгэмлэг энэхүү асуудлыг хамтран шийдвэрлэх үүрэгтэй” гэж тодорхой заасан байдаг. Эдийн засгийн өндөр хөгжилтэй улс орнууд энэ асуудлаар ядуу, хөгжиж буй улсуудад туслалцаа үзүүлэх онцгой үүрэг хариуцлага хүлээдэг.⁵⁸ Улс орнууд өөрийн харьяаллын хүрэн дэх Ковид-19 өвчний халдварын тархалтын хэмжээ, боломжит эмчилгээ, өвчний үр дагавар зэрэг холбогдох мэдээллийг бусад улс орнууд, олон улсын байгууллагуудад өгөх ёстой. Ковид-19 өвчлөл хурдацтай тархаж байгаа нь үүний эсрэг хангалттай хариу арга хэмжээ авах нөөцгүй байгаа зарим улс орнуудад нөлөөлж болзошгүй гэсэн айдсыг нэмэгдүүлж байна. Ийм үед олон улсын хамтын ажиллагаа, эв нэгдэл нэн чухал юм. Хариу арга хэмжээ авах боломжтой бүх улс орон аль болох хурдан ажиллах ёстой. Авах арга хэмжээнүүд нь хүний эрхийг хүндэтгэсэн, урт хугацааны болон нэн тэргүүний хэрэгцээг, мөн нийгмээс гадуурхагдсан бүлгийнхний онцгой, тодорхой хэрэгцээг харгалзан үзсэн байх учиртай.

Нийгмийн эрүүл мэндэд учирч буй аюулын үед иргэдийг хамгаалах, туслалцаа үзүүлэх нь нөлөөлөлд өртсөн улс орны төр засгийн хэрэгжүүлэх үүрэг, хариуцлага юм. Гэхдээ, өвчний халдварт өртөгсдөд туслалцаа дэмжлэг шаардлагатай байгаа нөхцөлд төрийн зүгээс олон улсын дэмжлэг хүсэх хэрэгтэй бөгөөд үндэсний болон орон нутгийн засаг захиргаа энэхүү туслалцааг үзүүлэхэд дэмжлэг үзүүлэх явдлыг баталгаажуулах ёстой. ДЭМБ зэрэг олон улсын байгууллагаар дамжуулан туслалцаа үзүүлэх тохиолдолд

⁵² ДЭМБ, Коронавирусийн халдвар 2019 (Ковид-19)-ын тархалт: Эрүүл мэндийн ажилтнуудын эрх, үүрэг болон ажиллах орчны эрүүл ахуй, аюулгүй байдлын гол асуудал, www.who.int/docs/default-source/coronaviruse/who-rights-roles-respon-hw-covid-19.pdf?sfvrsn=bcabd401_0

⁵³ Бизнес инсайдер, Хятадын 3400 орчим эрүүл мэндийн ажилтан коронавирусийн халдвар авч, 13 нь нас баржээ. 2020 оны 3 сарын 5, www.businessinsider.com/healthcare-workers-getting-coronavirus-500-infected-2020-2?r=US&IR=T

⁵⁴ Эмнести Интернэшнл: Эмч нарын үхэл коронавирусийн халдварын үеийн хүний эрхийн зөрчлийг харуулж байна. (Хэвлэлийн мэдээ, 2020 оны 2 сарын 7), www.amnesty.org/en/latest/news/2020/02/china-doctor-death-highlights-human-rights-failings-in-coronavirus-outbreak

⁵⁵ ЭЗНСЭОУП, Ерөнхий санал зөвлөмж №14, 36-р зүйл

⁵⁶ ДЭМБ, Коронавирусийн өвчлөл (Ковид-19) цар тахал: Ажлын байрны эрүүл аюулгүй байдалтай холбоотой гол асуудлууд зэрэг эрүүл мэндийн ажилтнуудын эрх ба үүрэг хариуцлага, www.who.int/docs/default-source/coronaviruse/who-rights-roles-respon-hw-covid-19.pdf?sfvrsn=bcabd401_0

⁵⁷ ЭЗНСЭХ, Ерөнхий санал зөвлөмж №14, 38, 45-р зүйл

⁵⁸ ЭЗНСЭХ, Ерөнхий санал зөвлөмж №14, 40-р зүйл

улс орнууд тэдгээр засгийн газар хоорондын байгууллагуудын гаргасан бодлого, шийдвэрийг гишүүн орнуудын хүлээсэн хүний эрхийн үүрэг хариуцлагатай нийцүүлэхийн тулд бүхий л арга хэмжээг авах үүрэгтэй.⁵⁹

Олон улсын хамтын ажиллагааны нэгэн чухал тал бол Ковид-19 өвчний тархалт, эрсдэл, хэрхэн урьдчилан сэргийлэх, эмчлэх аргуудын талаарх мэдээллээ гол оролцогчдод ил тод, үр дүнтэй хэлбэрээр хуваалцах явдал юм. Нөлөөлөлд өртсөн хүмүүс болон бүх оролцогч талын оролцоог хангасан дэлхийн хэмжээний уялдаа холбоотой хариу арга хэмжээ нь ч мөн ижил ач холбогдолтой юм. Эрүүл мэндтэй холбоотой эрхийн хүрээнд, “ эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн, хамаарал бүхий бүх талуудын оролцоо, хүчин чармайлт, түүний дотор иргэний нийгмийн бүхий л төлөөллийн оролцоо хамаарна.”⁶⁰

УРТ ХУГАЦААНЫ СЭРГЭЭН БОСГОХ ҮЙЛ ЯВЦ БА БИЕЛЭЛТИЙГ ЭРГЭН ХЯНАХ НЬ

Вирусийн тархалтад ихээр өртсөн улс орнуудын эрүүл мэндийн систем, эдийн засгийг сэргээн босгоход урт хугацаандаа олон улсын дэмжлэг, эв нэгдэл шаардлагатай болно. Ковид-19 цар тахал нь улс орнуудын эрүүл мэнд, нийгмийн хамгааллын систем, тогтолцоонд доголдол үүсгэж, үүнийг сэргээхийн тулд хөрөнгө оруулалт, цаг хугацаа шаардлагатай болох магадлалтай. Цар тахалд илүүтэй өртсөн, хохирсон бүлэгт чиглэсэн туслалцаа дэмжлэг хэрэгтэй байж болно. Урт хугацааны сэргээн босгох үйл ажиллагаа эрүүл мэндийн системийн сул хөгжилтэй улс орнуудыг дэмжих, бэхжүүлэхэд шаардлагатай. Цар тахалд өртсөн улс орнуудын хөгжил, эдийн засагт учруулсан нөлөөллийг анхаарах ёстойг Ковид-19 халдварын дэлхийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тайлан, мэдээллүүдэд тэмдэглэсээр байгаа⁶¹ бөгөөд нөөц багатай улс орнууд, жижиг аж ахуйн нэгж, мөн орлого багатай, баталгаагүй ажил эрхэлдэг хүмүүс үүний нөлөөнд ихээхэн хэмжээгээр өртөж болзошгүй байна. Урт хугацаанд сэргээн босгох аливаа стратеги энэхүү нөлөөлөл, болон тэдний илэрхийлж буй хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэх ёстой юм.

Ковид-19 цар тахлын эсрэг авч буй арга хэмжээнүүдээ хүний эрхийн олон улсын эрх зүй, хэм хэмжээнд нийцүүлж, эрсдэлт болон туслалцаа шаардлагатай бүлгийнхний онцгой хэрэгцээг анхаарах, хариу арга хэмжээний үеэрх хүний эрхийн болзошгүй зөрчлийн эрсдэлийг бууруулж шийдвэрлэхээ баталгаажуулахыг бүхий л улс орнууд, бусад оролцогчдод хандан Амнести Интернэшнлээс уриалж байна.

⁵⁹ Жишээ болгож ЭЗНСЭХ-ны Тайлагнах удирдамж (2008), 3(с) зүйл; Ерөнхий санал зөвлөмж №17, Хүн бүрийн, өөрийн бүтээсэн шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлийнхээ үр дүнд бий болсон ёс суртахууны болон материаллаг сонирхлыг хамгаалах болон үр шимийг нь хүртэх эрх. (15-р зүйл, догол мөр 1 (с), ЭЗНСЭОУП), НҮБ-ын баримт бичиг. E/C.12/GC/17 (2006), 56-р догол мөр-ийг үз. Мөн Олон Улсын Хөдөлмөрийн Эрх Зүйн Хороо, Олон улсын байгууллагуудын үүргийн талаарх нийтлэлүүдийн ноорог, НҮБ-ын баримт бичиг, A/66/10 (2011), Art. 61-62.

⁶⁰ ЭЗНСЭОУП, Ерөнхий санал зөвлөмж №14, 64-р зүйл.

⁶¹ Дэлхийн Эдийн Засгийн Форум, *Коронавирусийн эдийн засгийн өртөг – Айфоны нарны зайн хавтангаас аялал жуулчлал хүртэл*. 2020 оны 2 сарын 21, www.weforum.org/agenda/2020/02/economic-toll-coronavirus-manufacturing-tourism-china-asia/

